

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**



2025 оны 04 дүгээр сарын 08

Улаанбаатар хот

Дд	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	<p><b>Үүрэг, даалгавар ХОЁР:</b> Улс, нийслэлийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, цахим худалдаанаас татвар авах ажлыг зохион байгуулах.</p> <p>Улс, нийслэл, дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт 2025 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар дараах гүйцэтгэлтэй байна.</p> <p>Улсын төсөв 26,141,622.94 мянган төгрөг төвлөрүүлэх төвлөлөгөөтэйгөөс 33,649,199.09 мянган төгрөг төвлөрүүлж 128.7%, нийслэлийн төсөв 6,490,087.76 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,845,774.40 мянган төгрөг төвлөрүүлж 74.7%, дүүргийн төсөв 63,664,222.80 мянган төгрөг төвлөрүүлэх төвлөлөгөөтэйгөөс 61,604,749.74 мянган төгрөг төвлөрүүлж, 96.8%, нийт дүнгээрээ 2025 оны 01 дүгээр улиралд 96,295,933.50 мянган төгрөг төвлөрүүлэх төвлөлөгөөтэйгөөс 100,099,723.23 мянган төгрөг төвлөрүүлж 103.9%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна.</p>			100
2	<p><b>Үүрэг, даалгавар ГУРАВ:</b> Төсвийн тодотгол батлагдсантай холбогдуулан нийслэлийн хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлуудаа эрчимжүүлж ажиллах.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас 2025 оны 01 дүгээр улиралд дүүргийн Засаг даргад эрх шилжүүлсэн дараах ажлууд байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Нутгийн захиргааны барилгын ажил, тендер сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж тендерийг нээсэн бөгөөд үнэлгээ хийгдэж байна.</p> <p>Дүүргийн нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил, тендер сонгон шалгаруулалтыг зарласан бөгөөд тендерийн материал хүлээн авч байна.</p> <p>Дүүргийн орон нутгийн төсвийн тодотголоор Худалдан авах ажиллагааны ерөнхий төвлөлөгөөг шинэчилж тендер сонгон шалгаруулалтыг эрчимжүүлж бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв, боловсролын салбарын бүтээн байгуулалтын засвар шинэчлэлийн ажлуудыг шуурхайлахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирсэн өдөрт багтаан төсөл,</p>			50

	<p>арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг Төрийн Худалдан авах ажиллагааны газрын цахим систем болох <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д цахим системээр дамжуулан ил тод, нээлттэй зарлан шуурхай зохион байгуулан ажиллаж байна.</p> <p><b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Нийслэлийн хэмжээнд хөрөнгө оруулалтын ажлуудын газар чөлөөлөлтийг эрчимжүүлж, хэрэгжилтийг тогтмол танилцуулж ажиллах.</p>		
3	<p>1. 17 дугаар хороо, 960 хүүхдийн суудал бүхий сургууль барихад 48 нэгж талбар өртсөн байна. Үүнээс: Нөхөх олговортойгоор чөлөөлсөн 40 нэгж талбарт 4,242,428,000 тэрбум төгрөг, үлдсэн 8 нэгж талбараас үнэлгээний үнийн дүнгээс татгалзсан 5 нэгж талбар, 3 нэгж талбар төлөвлөлтийн хэсгээс хасаж өгөх тухай хүсэлт гаргасан.</p> <p>2. 13 дугаар хороо, "Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэг" барихад 22 нэгж талбар өртсөн Үүнээс: Зөвшилцсөн 17 нэгж талбар, зөвшөөрөөгүй 1 нэгж талбар, зөвшилцөх шатандаа 4 нэгж талбар 2,1 тэрбум төгрөг, шинээр 3 нэгж талбар нэмэгдсэн 429,000,000 төгрөг</p> <p>3. 8 дугаар хороо, 640 хүүхдийн суудал бүхий сургууль барихад нийт 47 нэгж талбар өртсөнөөс одоогийн байдлаар 42 нэгж талбарыг бүрэн чөлөөлөөд байна. Үлдсэн 5 нэгж талбартай зөвшилцөх ажил үргэлжилж байна.</p> <p>4. 9 дүгээр хороо, "Засаг захиргааны байр" 112 нэгж талбар өртсөнөөс чөлөөлсөн 101 нэгж талбар, үлдсэн 11 нэгж талбараас үнэлгээ хийлгэсэн 4 нэгж талбар, шинээр үнэлгээ хийлгэх 5 нэгж талбар, зургийн хасалтад орсон 1 нэгж талбар, үнэлгээнээс татгалзсан 1 нэгж талбар байна.</p> <p>5. 12 дугаар хороо, авто зогсоол тохижилтын ажлыг хийхэд нийт 5 нэгж талбар өртсөн, үүнээс 4 нэгж талбар зөвшилцөж захирамж боловсруулан хүргүүлсэн. Үлдсэн 1 нэгж талбар үнэлгээний үнийн дүнгээс татгалзсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналын дагуу 1 нэгж талбар нэмэхээр төлөвлөсөн. Нийт мөнгөн дүн 614,670,483 төгрөг</p> <p>6. 14 дүгээр хороо, Олон нийтийн барилга байгууламж, бусад зориулалтад өртсөн 15 нэгж талбар байгаагаас 6 нэгж талбартай зөвшилцөж 4 нэгж талбар үнэлгээний үнийн дүнгээс татгалзсан бөгөөд үлдсэн 5 нэгж талбарын үнэлгээний тайлан одоогоор ирээгүй байна.</p>		70
4	<p><b>Үүрэг, даалгавар ДОЛОО:</b> Нийтийн эзэмшлийн талбайг хашаалсан автомашины зогсоолыг чөлөөлж, ТҮЦ, хашаа, хайс, гарааш буулгах ажлыг эрчимжүүлэх.</p> <p>Дүүргийн Засаг даргын 2025 оны "Дүүргийн нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгах дэд ажлын хэсэг байгуулах тухай" А/44 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, авто зам болон явган хүний замыг хааж зохих байгууллагын зөвшөөрөлгүй дур мэдэн барьсан болон байрлуулсан стандарт бус хашаа, хайс,</p>		70

зөвшөөрөлгүй хаалт, автомат хаалт, тусгаарлах шон , гинж автомашины гарааш, зөврийн байгууламжийн зөрчлийг арилгах, газар чөлөөлөх арга хэмжээг Газар зохион байгуулалтын албаны даргын баталсан хуваарийн дагуу газар зохион байгуулагч нар 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2 байршлын 7 гарааш, 9 байршлын 11 хаалт, 9 байршлын 10 зогсоолын цэг, "Оранж" төвийн урьд талд байрлах 1 гараашийг тус тус буулгаж газрыг чөлөөлсөн.



Дүүргийн Засаг даргын 2025 оны "Газар албадан чөлөөлөх тухай" А/117 дугаар захирамжаар ТҮЦ буюу түргэн үйлчилгээний цэгийг албадан буулгах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж батлагдсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж талбайд байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг албадан буулгахаар бэлтгэл ажлыг бүрэн хангасан.

**Үүрэг, даалгавар НАЙМ:** Нийслэлийн хэмжээнд соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулж, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг хамгаалах, зэрэг ажлуудаа эрчимжүүлэх.

- Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:
1. Нийслэлийн 9 дүүргийн дунд зохион байгуулсан “Өвлийн фестивал” арга хэмжээнд дүүргийн 200 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийг хамруулж, тэргүүн байрт шалгарсан амжилтыг үзүүлсэн.
  2. “Б.Явуухулангийн нэрэмжит яруу найраг”-ийн тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, дүүргийн Ерөнхий боловсролын 15 сургуулийн 30 гаруй сурагчид хамрагдсан. Мөн 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр яруу найргийн дурсамж, өдөрлөгийг Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан.
  3. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын төрийн албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн Урлагийн наадам”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
  4. Дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад Хүүхэд багачуудын бие даалтын 7 хоногт музейн үзвэрээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх боломжтой талаар болон Хүүхэлдэйн театр”-аас сургуулийн амралтыг тохиолдуулан төлбөрийн 30% хөнгөлөлттэй үнээр үйлчилж байгаа мэдээллийг хүргэж ажилласан.
  5. “Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт”-ыг 2025 оны 03 дугаар сарын 27-оос эхлэн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаанд дүүргийн 1-24 хороодод 10 удаа зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн хамрагдаж, гарын авлага тараасан.
  6. Соёлын биет бус өв болох уртын дуу, бий биелгээг дэлгэрүүлэх, таниулан сурталчлах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Завсарлагааны дуу, бүжиг” аяныг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд өрнүүлж, ерөнхий боловсролын нийт 18 сургуулийн 12000 гаруй хүүхэд хамрагдаж байна.
  7. Ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийг нэг цагт, нэгэн зэрэг унших арга хэмжээг Чингэлтэй дүүрэгт “Тусгаар тогтнол”-ын талбайд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 12:00 цагт зохион байгуулсан.

**Үүрэг, даалгавар АРАВ:** Нохой, муур барих ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нэгдсэн байдлаар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах.

6	<p>Эзэнгүй золбин муур, нохойг барих, тоо толгойг бууруулах зэрэг ажлыг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нэгдсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөөд байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газрын 1, 2 дугаар хэлтэс, 1-24 дүгээр хороодын Засаг даргын ажлын алба, гэрээт гүйцэтгэгч байгууллага "Их булаг А ТҮК" ХХК-тай хамтран тус ажлыг зохион байгуулахаар нэгдсэн төлөвлөгөө, маршрутыг гарган бэлтгэл ажлыг хангаад байна.</p>			30
<p><b>Үүрэг, даалгавар АРВАН НЭГ:</b> Нийслэлийн хэмжээнд ой, хээрийн түймэр, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлуудыг шуурхай зохион байгуулах.</p>				
7	<p>Улсын Онцгой комиссын 2025 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн ой хээрийн гал түймэртэй тэмцэх шуурхай албаны 3 автомашин, ой хээрийн түймэр унтраах багаж хэрэгсэлд үзлэг шалгалт зохион байгуулж, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг 24 дүгээр хорооны Засаг даргын ажлын албатай хамтран өдөрлөг, сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж 100 гаруй иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх материалыг тарааж ажилласан бөгөөд тус хорооны ой, хээрийн түймрийн үед ашиглагдах багаж хэрэгслийг шалгаж заавар, зөвлөмж өгч ажилласан.</p>			100
<p><b>Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ:</b> Нийслэлийн хэмжээнд хороодын Засаг дарга нартай 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр уулзалт зохион байгуулах.</p>				
8	<p>Нийслэлийн төр захиргааны Хангарди ордны Хүндэтгэлийн танхимд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09.00 цагт зохион байгуулсан уулзалтад дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар, хороо хариуцсан мэргэжилтэн нарын 27 хүн бүрэн оролцсон. Тус уулзалтаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч зургаан чиглэлээр үүрэг даалгавар өгч, дүүрэг, хороодын Засаг дарга нарын санал, хүсэлтийг сонсож, шийдвэрлэлтийг хэлэлцэн, тухайн уулзалтыг сар болгон зохион байгуулахаар төлөвлөж буйгаа мэдэгдсэн.</p>			100
<p><b>Үүрэг, даалгавар ХОРИН НЭГ:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ хүүхэд, залуучууд, ахмадуудыг чөлөөтэй амрах талбайг бий болгож, халуун сүү худалддаг болох.</p>				
9	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газраас хүүхэд, залуучууд, ахмадуудыг чөлөөтэй амрах талбайг бий болгох чиглэлээр дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Зүрх уул, Чингэлтэй хайрхны чиглэлд явган алхалт хийх, амрах зам талбайг бий болгохоор холбогдох судалгааг хийж байна. Дүүргийн хэмжээнд 2025 оны</p>			70

	хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу нийт 38 цэцэрлэгийн 10250 гаруй хүүхэд, багачуудад өдөрт 1 удаа халуун сүү өгч ажиллаж байна.		73.3%
--	--	--	-------



**ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ**

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

О.БАТМӨНХ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ИЧИННОРОВ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ